

**ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН МАКАОГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ
ОНЦГОЙ БҮСИЙН ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын Төв Засгийн газраас энэхүү Хэлэлцээрийг байгуулах бүрэн эрх олгосны дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн Засгийн газар (цаашид "Макаогийн ЗЗОБ" гэх)

болон

Монгол Улсын Засгийн газар

(цаашид "Хэлэлцэн тохирогч талууд" гэх),

Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалах нь хүний эрхийг ноцтой зөрчиж, нэр төрийг нь гутааж, бие махбодь, сэтгэл зүй, зан ааш, ёс суртахууны хөгжилд нь сөргөөр нөлөөлж, нийгмийн харилцаа болон үнэт зүйлсийг доройтуулж буйд сэтгэл түгшин,

Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хохирогчдыг хамгаалах, туслах талаар хамтран ажиллах зорилгоор,

Дараахь зүйлсийг харилцан тохиров:

**I БҮЛЭГ
ЕРӨНХИЙ ЗААЛТ
1 дүгээр зүйл
Зорилго**

Энэхүү Хэлэлцээрийн зорилго нь олон улсын эрх зүй болон Хэлэлцэн тохирогч талуудын хүчин төгөлдөр дотоодын хууль тогтоомжийг бүрэн хүндэтгэх, харилцан адил байх зарчмын үндсэн дээр хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

**2 дугаар зүйл
Хэрэглэх хүрээ**

Энэхүү Хэлэлцээрийг:

- а) хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;
- б) хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, эх оронд нь буцаах, нийгэмшүүлэхтэй холбогдуулан хэрэглэнэ.

**3 дугаар зүйл
Нэр томъёог хэрэглэх**

Энэхүү Хэлэлцээрийн зорилгоор:

- а) "хүн худалдаалах" гэж хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Мөлжих гэдэгт наад зах нь бусдыг биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно;
- б) "хүүхэд" гэж 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ;
- с) "Макаогийн ЗЗОБ-д байнга оршин суугч" гэж Макаогийн ЗЗОБ-д байнга оршин суух эрхтэй хүн бүрийг хэлнэ.

II БҮЛЭГ
ХАМТЫН АЖИЛЛАГАА
4 дүгээр зүйл
Хэрэгжүүлэгч байгууллага

- 1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэгч байгууллага нь Макаогийн ЗЗОБ-ийн Аюулгүй байдлын Нарийн бичгийн дарга болон Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам байна.
- 2. Хэрэгжүүлэгч байгууллага дараахь үүрэгтэй:
 - а) энэхүү Хэлэлцээрийн зорилгыг хангах хүрээнд хамтран ажиллах, мөн хүрээнд Хэлэлцэн тохирогч талуудын бусад холбогдох эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
 - б) энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад үүссэн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх арга замыг боломжийн хэмжээнд эрэлхийлэх;
 - с) Хэлэлцэн тохирогч талуудын хоорондын туршлагыг үнэлж дүгнэх, тэдгээрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх санал боловсруулах үүднээс энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хоёр жил тутамд хэлэлцэн дүгнэх;
 - д) энэхүү Хэлэлцээрийн 16 дугаар зүйлд заасан Зохицуулах төвийг томилох, түүний үйл ажиллагааны удирдлага, чиглэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх.

5 дугаар зүйл
Хамтын ажиллагааны хүрээ, хэлбэр

- 1. Хэлэлцэн тохирогч талууд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, гэмт этгээдүүдийг олж тогтоох, хууль, шүүхийн өмнө хариуцлага хүлээлгэх, хохирогчдыг хамгаалах талаар нягт хамтран ажиллана.
- 2. Хэлэлцэн тохирогч талууд хүсэлт тавьсан тохиолдолд тэдгээрийн холбогдох эрх бүхий байгууллагууд дотоодын хууль тогтоомжийн дагуу өөрийн чиг үүргийн хүрээнд хүн худалдаалж буй чиглэл, газар, сүлжээ, арга, хэлбэр зэрэг хүн худалдаалахтай холбоотой мэдээ, мэдээллийг нэгтгэх, харилцан солилцох, нотлох баримт цуглуулах ажлыг гүйцэтгэх нөхцлийг хангана.
- 3. Энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд хор хохирол учруулахгүйгээр харилцан солилцсон мэдээ, мэдээлэл, нотлох баримтын нууцлалыг хадгалах бөгөөд тухайн мэдээ, мэдээлэл, нотлох баримтаар хангасан Хэлэлцэн тохирогч

талын эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд тэдгээрийг дамжуулж болохгүй.

6 дугаар зүйл Туслалцаа авах хүсэлт

1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээн дэх хамтын ажиллагаа нь туслалцаа авах хүсэлтэд үндэслэнэ.
2. Онцгой яаралтай тохиолдолд туслалцаа авах хүсэлтийг амаар тавьж болох бөгөөд долоо хоногийн дотор бичгээр нотлох шаардлагатай. Бусад бүх тохиолдолд туслалцаа авах хүсэлтийг бичгээр тавина.
3. Туслалцаа авах хүсэлт нь дараахь агуулгатай байна.
 - а) Туслалцаа авах хүсэлтийн төрөл;
 - б) Туслалцаа авах хүсэлтийн зорилго, шалтгаан зэрэг холбогдох мэдээ, мэдээлэл;
 - в) Туслалцаа авах хүсэлтийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад бүх төрлийн мэдээлэл.
4. Туслалцаа авах хүсэлтэд Хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага гарын үсэг зурсан байна.

7 дугаар зүйл Хүсэлтийг хэрэгжүүлэх

1. Туслалцаа авах хүсэлтийг аль болох хурдан хэрэгжүүлнэ
2. Хэрэв хүсэлтийг хэрэгжүүлэх ажиллагаа хойшлогдох аливаа нөхцөл байдал үүсвэл хүсэлт тавьсан Хэрэгжүүлэгч байгууллагад нэн даруй мэдэгдэнэ
3. Хэрэв хүсэлтийг хэрэгжүүлэх нь хүсэлт хүлээн авсан Хэрэгжүүлэгч байгууллагын эрх мэдлийн хүрээнд хамаарахгүй бол хүсэлт тавьсан Хэрэгжүүлэгч байгууллагад энэ талаар нэн даруй мэдэгдэнэ.
4. Хүсэлт хүлээн авсан Хэрэгжүүлэгч байгууллага хүсэлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээллийг шаардаж болно.
5. Хүсэлт хүлээн авсан Хэрэгжүүлэгч байгууллага хүсэлтийг шууд хэрэгжүүлэх нь тухайн талын хууль тогтоомжийн хүрээнд явагдаж буй эрүүгийн байцаан шийтгэх болон мөрдөн шалгах үйл ажиллагаанд саад учруулна гэж үзвэл тухайн хүсэлтийг хэрэгжүүлэхийг хойшлуулах, эсхүл тодорхой нөхцөлтэйгээр хэрэгжүүлэхийг зөвшөөрч болно.
6. Хүсэлт хүлээн авсан Хэрэгжүүлэгч байгууллага хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хүсэлт гаргасан Хэрэгжүүлэгч байгууллагад аль болох хурдан мэдэгдэнэ.

8 дугаар зүйл Хэрэгжүүлэхээс татгалзах

1. Туслалцаа авах хүсэлтийг хэрэгжүүлэх нь хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч талын хүчин төгөлдөр дотоодын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд харшилж байвал хэрэгжүүлэхээс татгалзаж болно.
2. Хүсэлтийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар хүсэлт гаргасан Хэрэгжүүлэгч байгууллагад бичгээр мэдэгдэх ёстой.

9 дүгээр зүйл
Мэдээллийг хамгаалах

1. Хувийн мэдээллийг зөвхөн энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тохиолдолд дамжуулна.
2. Хувийн мэдээллийг дамжуулах, боловсруулах, хамгаалах үйл ажиллагаа нь Хэлэлцэн тохирогч талуудын дотоодын хууль тогтоомжид нийцсэн байна.
3. Энэхүү зүйлийн 1, 2 дахь заалтад хор хохирол учруулахгүйгээр дараахь журмыг баримтална:
 - a) Хувийн мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд, үнэн зөв боловсруулна;
 - b) Хувийн мэдээллийг хүлээн авагч Хэлэлцэн тохирогч тал гагцхүү энэхүү Хэлэлцээрт тухайн мэдээллийг дамжуулахаар заасан зорилгоор ашиглана. Мэдээлэл дамжуулсан Хэлэлцэн тохирогч талаас урьдчилан зөвшөөрөл авсан тохиолдолд тухайн мэдээллийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч талын дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн өөр зорилгоор ашиглаж болно;
 - c) Хувийн мэдээллийг зөвхөн Хэлэлцэн тохирогч талаас томилсон шүүхийн, эсхүл хууль хэрэгжүүлэх байгууллага ашиглаж болох бөгөөд ийм байгууллагын жагсаалтыг Хэлэлцэн тохирогч нөгөө талдаа гаргаж өгнө;
 - d) Хэлэлцэн тохирогч тал дамжуулж буй мэдээллийн үнэн зөв байдлыг хангах үүрэгтэй. Мэдээлэл алдаатай, эсхүл дамжуулах ёсгүй байсан бол хүлээн авагч Хэлэлцэн тохирогч талд энэ талаар заавал мэдэгдэх ёстой бөгөөд холбогдох тал нь уг мэдээллийг засах, эсхүл устгах үүрэг хүлээнэ;
 - e) Хэлэлцэн тохирогч нэг тал дотоодынхоо хууль тогтоомжийн дагуу хохирогчийн өмнө хариуцлага хүлээхгүйн тулд алдаатай мэдээлэл дамжуулсан гэж Хэлэлцэн тохирогч нөгөө талыг буруутгаж болохгүй;
 - f) Мэдээллийг дамжуулах болон ашиглах үйл ажиллагаа нь холбогдох хүнээс ийм хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч талын дотоодын хууль тогтоомжоор зохицуулагдана. Ингэхдээ мэдээллийг тухайн хүнд зөвхөн уг мэдээллийг анх өгсөн Хэлэлцэн тохирогч талын зөвшөөрөлтэйгээр дамжуулж болно;
 - g) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн тухай хувийн мэдээлэл нь хангалттай, хамааралтай байх бөгөөд тухайн мэдээллийг цуглуулах, цаашид боловсруулах зорилгод нийцсэн агуулга, хэмжээнд байх ёстой. Дамжуулах хувийн мэдээлэл нь зөвхөн дараахь агуулгатай байвал зохино:
 - i. Хохирогчийн тухай мэдээлэл (үүнд жишээлбэл овог, нэр, өмнө авч байсан нэр, хоч, эсхүл нууц нэр, төрсөн огноо болон газар, хүйс, одоогийн болон өмнөх иргэний харьяалал, эсхүл байнга оршин суудаг газар);
 - ii. Үнэмлэх, эсхүл паспорт (дугаар, хүчинтэй хугацаа, олгосон огноо, олгосон байгууллага, олгосон газар);
 - iii. Буудалласан газрууд болон аялалын хуваарь;
 - iv. Хохирогчийг таних, эсхүл хамгаалахад шаардлагатай бусад мэдээлэл.
 - h) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн тухай хувийн мэдээллийг хэнийх болохыг тодорхойлох боломжтой хэлбэрээр, мэдээллийг цуглуулсан, эсхүл цаашид боловсруулах зорилгод шаардлагатайгаас илүүгүй хугацаагаар хадгална.

4. Хувийн мэдээллийг илгээх болон хүлээн авах бүртгэл хөтөлнө. Хэлэлцэн тохирогч талууд энэхүү бүртгэлтэй танилцах эрх бүхий байгууллага, эсхүл албаны жагсаалтыг хоорондоо харилцан солилцоно.

III БҮЛЭГ
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
10 дугаар зүйл
Урьдчилан сэргийлэх ерөнхий зарчмууд

Хүн худалдаалахыг таслан зогсоохтой холбоотойгоор Хэлэлцэн тохирогч талуудад үйлчилж буй олон улсын гэрээнд нийцүүлэн Хэлэлцэн тохирогч талууд өөрсдийн хууль тогтоомжоо хэрэгжүүлэх, бүрэн эрхээ эдлэх баталгааг хангана.

11 дүгээр зүйл
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хэлэлцэн тохирогч талууд нь хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх талаар дараахь арга хэмжээг авна:

- а) боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх бололцоог дээшлүүлэх, хүн худалдаалахад өртөх эрсдэлийг багасгах зорилгоор эмэгтэйчүүд, хүүхдүүдийг боловсролын болон мэргэжлийн сургалтад хамруулах хөтөлбөр хэрэгжүүлэх;
- б) хүн худалдаалахад өртөх эрсдэлтэй эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зориулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн халамж үзүүлэх зэрэг нийгмийн үйлчилгээг сайжруулах;
- с) хүн худалдаалах талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, хүн худалдаалахад хүргэж буй эрсдэлтэй хүчин зүйлсийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх.

12 дугаар зүйл
Сургалт

Хэлэлцэн тохирогч талууд хууль тогтоомжоо хэрэгжүүлэх, хүн худалдаалах болон холбогдох гэмт хэргийн үед мөрдөн шалгах, байцаан шийтгэх болон хамгаалах талаарх өөрсдийн холбогдох байгууллагын чадавхийг дээшлүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрийг дангаараа болон хамтран хэрэгжүүлнэ.

IV БҮЛЭГ
ХОХИРОГЧДЫГ ХАМГААЛАХ, ЭХ ОРОНД НЬ БУЦААХ
БОЛОН НИЙГЭМШҮҮЛЭХ
13 дугаар зүйл
Хамгаалалтын ерөнхий зарчмууд

Хэлэлцэн тохирогч талууд холбогдох олон улсын гэрээнд заасан хохирогчдыг хамгаалах ерөнхий зарчмуудыг, тухайлбал үл алагчлах, мэдээлэл авах, хувийн эрх чөлөө, нууцыг хамгаалах, хохирогч хүүхдийн хувьд хүүхдийн эрх ашгийг дээдлэх, хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зэрэг зарчмуудыг хүндэтгэж баталгаажуулна.

14 дүгээр зүйл
Хамгаалалтын тусгай арга хэмжээ

1. Хэлэлцэн тохирогч талууд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг авна. Тухайлбал:
 - а) хохирогчдыг эрүүгийн хариуцлагад татахгүй байх, хууль бусаар цагаачилсан, эсхүл биеэ үнэлсэн зэрэг хүн худалдаалахтай холбоотой бусад эрүүгийн хэрэгт холбогдуулан түр хорьж саатуулахгүй байх;
 - б) хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг албан ёсоор эх оронд нь буцаах хүртэл саатуулах төвд саатуулахгүй байх;
 - в) хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт байх үед Хэлэлцэн тохирогч тухайн талын эрх бүхий байгууллага түүний биеийн аюулгүй байдлыг хангаж байх;
 - д) хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, эх оронд нь буцаах, асуудлыг нь шүүхээр шийдвэрлэх бүх хугацаанд түүнтэй хүнлэг ёсоор харьцах.

15 дугаар зүйл
Хохирогчийн эрх

1. Хохирогчид, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд нь тэдгээрийг эх оронд нь буцаах үйл ажиллагаа дуусахыг хүлээх хугацаанд хууль, шүүхээр эрхээ хамгаалуулах, эрх зүйн хамгаалалтад байх эрхтэй.
2. Хэлэлцэн тохирогч талууд дараахь нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг авна:
 - а) хохирогч нь эрүүгийн хэргийг шүүн таслах ажиллагаа явуулах, тухайлбал шаардлагатай хууль зүйн туслалцаа авах, учирсан хохирлоо барагдуулах болон шүүхийн бусад хамгаалалтыг авах баталгаагаар хангагдана;
 - б) хохирогч нь хүн худалдаалахтай холбогдон учирсан хохирлоо гэмт этгээдээр нөхөн төлүүлэхээр нэхэмжилж болно;
 - в) хохирогч нь гэмт этгээдийн албадлагаар үнэ төлбөргүй үзүүлсэн үйлчилгээний төлбөрөө гэмт этгээдээс нэхэмжилж болно.
3. Хэлэлцэн тохирогч талууд хохирогчид, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг түр байр, эрүүл мэндийн үйлчилгээ, зохих ёсны хамгаалалтаар хангана.

16 дугаар зүйл
Зохицуулах төв

1. Хэлэлцэн тохирогч талууд хохирогчийг эх оронд нь буцаах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх, хохирогчийг эх оронд нь буцаахдаа аюулгүй байдлыг нь хангах зорилгоор Зохицуулах төвийг томилно.
2. Хэлэлцэн тохирогч талуудын Зохицуулах төвүүд хохирогчийг эх оронд нь буцаахдаа хохирогчийн нэр болон түүнтэй холбоотой мэдээ, мэдээллийг Хэлэлцэн тохирогч нөгөө талын Зохицуулах төвд урьдчилан мэдээлнэ.

17 дугаар зүйл
Хохирогчдыг эх оронд нь буцаах

1. Хохирогчдыг эх оронд нь буцаах ажиллагааг олон улсын холбогдох гэрээнд нийцүүлэн Хэлэлцэн тохирогч талуудын дотоодын хууль тогтоомжийн хүрээнд тэдгээрийн нэр хүндийг хүндэтгэн шуурхай, аюулгүй байдлыг нь ханган зохион байгуулна.

2. Хохирогчдыг эх оронд нь буцаахын өмнө Хэлэлцэн тохирогч холбогдох талын Зохицуулах төв шилжүүлэх өдөр, хилээр нэвтрэх боомт, дагалдаж болзошгүй хүний талаарх зохицуулалтыг урьдчилан бичгээр мэдэгдэнэ.
3. Эх оронд нь буцаах баримт бичиг дараахь мэдээллийг агуулна:
 - а) Эх оронд нь буцаах хохирогчийн талаарх мэдээлэл (үүнд жишээлбэл овог, нэр, төрсөн өдөр болон боломжтой бол төрсөн газар, хамгийн сүүлд оршин сууж байсан газар);
 - б) Эх оронд нь буцаах хохирогчийн харьяалал, эсхүл байнга оршин суудаг газрыг нь нотлох нотолгоо, эсхүл үндэслэл бүхий баримтыг тодорхойлох, боломжтой тохиолдолд эдгээр баримт бичгийн хуулбарыг өгөх;
 - в) Эх оронд нь буцаах хохирогчид тусламж, асрамж шаардлагатайг боломжтой хэлбэрээр тодорхойлсон мэдэгдэл, гэхдээ тухайн хүн уг мэдэгдлийг илэрхий зөвшөөрсөн байх;
 - д) Хувь хүнийг эх оронд нь буцаах тохиолдолд шаардлагатай байж болох бусад бүх хамгаалалт, аюулгүй байдлын арга хэмжээ.
4. Хэлэлцэн тохирогч нэг талын хүсэлтээр Хэлэлцэн тохирогч нөгөө тал эх оронд нь буцаах хохирогчид доод тал нь зургаан сарын хугацаанд хүчинтэй зорчих баримт бичгийг аль шаардлагатай богино хугацаанд хийж олгоно. Хэрэв хууль тогтоомжийн болон бодит шалтгааны улмаас тухайн хохирогчийг анх олгосон зорчих баримт бичгийн хүчинтэй хугацаанд багтаан шилжүүлж чадаагүй нөхцөлд шинэ зорчих баримт бичгийг мөн адил хүчинтэй хугацаагаар 14 (арван дөрөв) хоногийн дотор хийж олгоно.

18 дугаар зүйл Зардал

1. Хэлэлцэн тохирогч талууд энэхүү Хэлэлцээрт дурдсан өөрсдийн үйл ажиллагаа, хариуцлагаас үүдэн гарах зардлыг тус, тусдаа хариуцна.
2. Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагын гуравдагч этгээдээр холбогдох зардлыг даалгахтай холбоотойгоор эдлэх эрхийг хөндөхгүйгээр энэхүү Хэлэлцээрийн дагуу эх оронд нь буцаах хохирогчийн тээврийн болон дамжин өнгөрөх бүх зардлыг тухайн хохирогч харъяат нь болох, эсхүл байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч тал хариуцна.
3. Тодорхой хэргүүдийн хувьд Хэлэлцэн тохирогч талуудын Хэрэгжүүлэгч байгууллагууд энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн дагуу гарсан зардлыг Хэлэлцэн тохирогч талууд хувааж, эсхүл аль нэг тал бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хариуцаж гаргах асуудлыг харилцан тохиролцоно.

19 дүгээр зүйл Нийгэмшүүлэх

1. Хэлэлцэн тохирогч талууд хохирогчид, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийн нэр хүнд, эрх чөлөө болон өөрийгөө хүндэтгэх үзлийг нь сэргээх үүднээс нийгэм, гэр бүлдээ эргэн нийлэхэд нь туслах талаар боломжтой бүх чармайлтыг гаргана.
2. Хэлэлцэн тохирогч талууд хохирогчдын амьдралаа цогцлоох олон талын нөхцөл бололцоог дээшлүүлэх, тэднийг үр нөлөөтэй нийгэмшүүлэх зорилгоор амьдрах чадварын сургалт зэрэг мэргэжлийн сургалтын хөтөлбөр, мөн хохирогчдын хөгжлийн асуудлыг хариуцсан албан тушаалтнуудын мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

**V БҮЛЭГ
ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ
20 дугаар зүйл**


Хүчин төгөлдөр болох, хүчинтэй байх хугацаа болон цуцлах

1. Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч талууд дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн тухайгаа бичгээр харилцан мэдэгдсэнээс хойш гурав дахь сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү зүйлийн 3 дахь заалтын дагуу цуцлаагүй бол энэхүү Хэлэлцээр нь хүчин төгөлдөр байна.
3. Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь хэдийд ч Хэлэлцэн тохирогч нөгөө талдаа бичгээр мэдэгдэн энэхүү Хэлэлцээрийг цуцалж болно. Ийнхүү цуцлах нь Хэлэлцэн тохирогч нөгөө тал уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Хэлэлцээрийг Макао хотноо 2010 оны 10 дугаар сарын 18-ны өдөр хятад, монгол, англи хэл дээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлах явцад санал зөрвөл англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН зохих ёсоор эрх олгогдсон дараахь төлөөлөгчид энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН МАКАОГИЙН ЗАСАГ
ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ
БҮСИЙН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

